



ЭРҮҮЛ МЭНДИЙН
ЯАМ



ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХӨГЖЛИЙН ТӨВ



ДЭЛХИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА



ЭМ ЗҮЙН
СУРГУУЛЬ

ЭМ ЗҮЙН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ -2018

Улаанбаатар хот
2019 он

Эрхэлсэн: Н.Гэрэлт-Од, ЭМЯ-ны ЭҮТГ-ын дарга

Хянасан: Г.Цэцэнсанаа, ЭМЯ-ны ЭҮТГ-ын ЭЭХҮХ-ийн дарга
Ш.Энхзаяа, ЭМХТ, ЭЭТТА-ны дарга

Эмхэтгэсэн: С.Пүрэвсүрэн, АШУҮИС-ийн Эм зүйн сургууль
Ш.Ариунзаяа, ЭМХТ, ЭЭТТА-ны мэргэжилтэн

Мэдээлэл цуглуулсан:

Т.Мөнхтуул, ЭҮТГ-ын ЭЭХҮХ-ийн мэргэжилтэн
Ш.Ариунзаяа, ЭМХТ, ЭЭТТА-ны мэргэжилтэн
Ц.Болортуяа, ЭМХТ, ЭЭТТА-ны мэргэжилтэн
Д.Бямбадорж, ЭМХТ, ЭЭТТА-ны мэргэжилтэн
Ц.Мөнх-Од, ЭМХТ, ЭЭТТА-ны мэргэжилтэн

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

Хаяг: Засгийн газрын VIII байр Олимпийн гудамж - 2,
Сүхбаатар дүүрэг 14210 Монгол улс

Факс: 11-320916

Утас: 51-263913

Э-шуудан: info@mohs.gov.mn
www.mohs.mn

ГАРЧИГ

1. ХҮН АМ ЗҮЙН БОЛОН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

1.1	Монгол улсын хүн ам	7
1.2	Эрүүл мэндийн үзүүлэлт	8
1.2.1.	Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан	8
1.2.2.	Хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан	8

2. ЭМ ЗҮЙН САЛБАРЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

2.1.	Эрх зүй, бодлого	10
2.2.	Эм хангамжийн байгууллагын үзүүлэлт	13
2.2.1.	Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр	13
2.2.2.	Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага	14
2.2.3.	Эмийн сан	14
2.3.	Хүний нөөцийн үзүүлэлт	17
2.4.	Эдийн засгийн үзүүлэлт	20
2.4.1.	Эмийн санхүүжилт	20
2.4.2.	Эмийн үйлдвэрлэл, худалдаа	20
2.4.2.1.	Эмийн импорт	20
2.4.2.2.	Эмийн үйлдвэрлэл	23
2.4.3.	Эм худалдан авах ажиллагаа, түгээлт	24
2.5.	Эмийн зохицуулалт	26
2.5.1.	Эмийн бүртгэл	26
2.5.2.	Хяналт шалгалт	31
2.5.3.	Зах зээлийн ба чанарын хяналт	31
2.5.4.	Эмийн аюулгүй байдал	33
2.5.5.	Эмийн сонголт, эмийн зохистой хэрэглээ	34

ӨМНӨХ ҮГ



Эм зүйн салбарын үндсэн үзүүлэлтийг эмхэтгэн, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид болон бусад хэрэглэгчдийн хүртээл болгох нь эм зүйн төдийгүй эрүүл мэндийн салбарын ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой билээ.

Тав дахь удаагийн энэхүү эмхэтгэлд эм зүйн салбарын хүний нөөц, эм хангамжийн байгууллага, эдийн засгийн тоон мэдээлэл болон эмийн бүртгэл, чанар аюулгүй байдал, зохистой хэрэглээтэй холбоотой статистик үзүүлэлтийг өмнөх онуудтай харьцуулан тусгаж, эрхэм хэрэглэгч Та бүхэнд толилуулж байна.

Тогтвортой хөгжлийн зорилтыг хангах, бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад хүрэх зорилгоор “Эрүүл мэнд-8/20” зорилтыг Эрүүл мэндийн яамнаас дэвшүүлэн ажиллаж байгаа бөгөөд энэхүү зорилтын нэн тэргүүнд эмийн чанар, аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудал тавигдаж байгааг хэлэхэд таатай байна.

Зорилтыг хангах олон арга хэмжээг цаашид хэрэгжүүлж, жил бүрийн “Эм зүйн салбарын үндсэн үзүүлэлт” эмхэтгэлд тусган, хэрэглэгч Та бүхний хүртээл болгох болно.

Та бүгдийн ажилд амжилт хүсье.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Д.САРАНГЭРЭЛ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Хүн ам зүйн үзүүлэлтүүд /2013-2018 он/
- Хүснэгт 2. Эмийн сан, байршлаар, 2018 он
- Хүснэгт 3. Эмийн сангийн тусгай зөвшөөрөл, байршлаар, 2018 он
- Хүснэгт 4. Эм зүйч, эм найруулагчийн тоо, тусламж үйлчилгээний шатлалаар /2013-2018 он/
- Хүснэгт 5. Эм зүйч, эм найруулагчийн тоо, аймгаар, 2018 он
- Хүснэгт 6. Эм зүйн салбарын эдийн засгийн зарим үзүүлэлт, 2013-2018 он
- Хүснэгт 7. Эмийн гаж нөлөөний бүртгэл, 2013-2018 он
- Хүснэгт 8. Монгол улсын Зайлшгүй шаардлагатай эмийн үндэсний жагсаалт

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүн амд /2013-2018 он/
- Зураг 2. Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүн амд, 2013-2018 он
- Зураг 3. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрийн үйл ажиллагааны чиглэл, 2018 он
- Зураг 4. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллагын тоо, 2013-2018
- Зураг 5. Ханган нийлүүлэх байгууллагын үйл ажиллагааны чиглэл, 2013-2018 он
- Зураг 6. Тусгай зөвшөөрөл олгосон ханган нийлүүлэх байгууллагын үйл ажиллагааны чиглэл, 2018 он
- Зураг 7. Эм зүйч, эм найруулагчийн тоо, 2013-2018 он
- Зураг 8. Эм зүйч мэргэжлээр төгсөгчдийн тоо, 2013-2018 он
- Зураг 9. Эм найруулагч мэргэжлээр төгсөгчдийн тоо, 2013-2018 он
- Зураг 10. Эм зүйч, эм найруулагч мэргэжлээр төгсөгчдийн тоо, 2013-2018 он
- Зураг 11. Эрүүл мэндийн салбарын төсөв, тэрбум төгрөг, 2013-2018 он
- Зураг 12. Эмийн импорт, борлуулалт 2013-2018 он
- Зураг 13. Эмийн түүхий эдийн импорт, борлуулалт, тэрбум төгрөгөөр, 2013-2018 он
- Зураг 14. Эмнэлгийн хэрэгслийн импорт, борлуулалт, тэрбум төгрөгөөр, 2013-2018 он
- Зураг 15. Урвалж, оношлуурын импорт, борлуулалт, тэрбум төгрөгөөр, 2013-2018 он
- Зураг 16. Урвалжын импорт, борлуулалт, тэрбум төгрөгөөр, 2013-2018 он
- Зураг 17. Оношлуурын импорт, борлуулалт, тэрбум төгрөгөөр, 2013-2018 он
- Зураг 18. Монгол улсад импортолсон бүтээгдэхүүн, нэр төрлөөр, 2014-2018 он /давхардсан тоогоор/
- Зураг 19. Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тэрбум төгрөгөөр, 2013-2018 он
- Зураг 20. Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл, 2013-2018 он

- Зураг 21. Эм, эмнэлгийн хэрэгслийн төсөвт өртөг ба худалдан авах ажиллагааны гэрээний дүн, тэрбум төгрөгөөр, 2013-2018 он
- Зураг 22. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан гүйцэтгэлийн дүн, тэрбум төгрөгөөр, 2013-2018 он
- Зураг 23. Төлбөрийг нь төр хариуцах эм, тэрбум төгрөгөөр, 2013-2018 он
- Зураг 24. Монгол улсын эмийн бүртгэлд шинээр бүртгэгдсэн эм, эмийн түүхий эдийн тоо, оноор, 1994-2018 он
- Зураг 25. Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм, эмийн түүхий эдийн тоо, 2013-2018 он
- Зураг 26. Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм, АТС ангиллаар, 2013-2018 он
- Зураг 27. Бүртгэлтэй эмийн олгох нөхцөл /%/ , 2018 он
- Зураг 28. Монгол улсын эмийн бүртгэлд эм бүртгүүлсэн эхний 10 улс, 2018 он
- Зураг 29. Эмийн бүртгэлд үндэсний үйлдвэрийн эмийн эзлэх хувь, 2013-2018 он
- Зураг 30. Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм, АТС ангиллаар, 2018 он
- Зураг 31. Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, эм төрлөөр, 2014-2018 он
- Зураг 32. Үндэсний үйлдвэрийн эмийн бүртгэл
- Зураг 33. Уламжлалт эмийн бүртгэл, 2014-2018 он
- Зураг 34. Хяналт шалгалтад хамрагдсан эм хангамжийн байгууллагын тоо, 2013-2018 он
- Зураг 35. Хяналт шалгалтад хамрагдсан эм хангамжийн байгууллагын хувь, 2013-2018 он
- Зураг 36. Шинжилгээнд хамрагдсан дээж, 2013-2018 он
- Зураг 37. Нийт шинжилсэн ба чанарын шаардлага хангаагүй дээжийн тоо, 2013-2018 он
- Зураг 38. Чанарын шаардлага хангаагүй дээжийн эзлэх хувь, 2013-2018 он
- Зураг 39. Зөвшөөрөл олгогдсон зар сурталчилгааны тоо, 2015-2018 он
- Зураг 40. Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнд олгосон зар сурталчилгааны тоо, 2015-2018 он

ХҮН АМ ЗҮЙН БОЛОН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

1.1. Монгол улсын хүн ам

Монгол улсын хүн ам 2018 онд 3 сая 238.4 мянга болж, өмнөх оныхоос 60.5 мянган хүн буюу 1.9 хувиар өссөн байна. Нийт хүн амын 67.8 хувь нь хот суурин газар, үлдсэн 32.2 хувь нь хөдөө амьдарч байна. Улаанбаатар хотод 1491.3 мянган хүн буюу нийт хүн амын 46.1 хувь нь оршин сууж байна. Хүн амын 49.2 хувь нь эрэгтэйчүүд, 50.8 хувь нь эмэгтэйчүүд байгаа ба хүйсийн харьцаагаар 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 97 байна. Насны бүтцээр авч үзвэл 15 хүртэлх насны хүүхэд 31.2 хувийг, 15- 64 насны хүн ам 64.7 хувийг, 65-аас дээш насны хүн ам 4.1 хувийг тус тус эзэлж байна. 2018 оны байдлаар өрхийн тоо 894.5 мянга, үүнээс 64.4 хувь нь хотод, 35.6 хувь нь хөдөө байна. Улаанбаатар хотод 387.5 мянган өрх, хангайн бүсэд 176.7, төвийн бүсэд 152.1, баруун бүсэд 107.7, зүүн бүсэд 67.9 мянган өрх байгаа бөгөөд улсын дунджаар нэг өрхөд 3.6 хүн ногдож байна /Хүснэгт 1/.

Хүснэгт 1. Хүн ам зүйн үзүүлэлтүүд /2013-2018 он/

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018
Нийт хүн (мян)	2930.3	2995.9	3057.7	3119.9	3177.9	3238.4
Хотын хүн ам (хувиар)	68.1	66.4	68.0	68.9	67.6	67.8
Хөдөөгийн хүн ам (хувиар)	31.9	33.6	32.0	31.1	32.4	32.2
Насны бүлгээр (хувиар)						
0-15	27.4	28.0	29.6	30.0	30.5	31.2
15-64	68.8	68.0	66.6	66.2	65.7	64.7
65 аас дээш	3.8	4.0	3.8	3.8	3.9	4.1
Хүн ам зүйн коэффициентууд						
Төрөлтийн ерөнхий коэффициент	27.5	27.6	26.7	25.3	24.0	24.5
Нас баралтын ерөнхий коэффициент	5.6	5.6	5.4	5.2	5.1	5.1
Цэвэр өсөлт	2.2	2.2	2.1	2.1	2.2	1.9
Төрөлтийн нийлбэр коэффициент	3.0	3.1	3.1	3.0	2.8	2.9

Төрөлтөөс тооцсон дундаж наслалт 2018 онд 70.19 болж өмнөх оныхоос 0.34 пунктээр нэмэгдсэн бөгөөд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.78 болж болж 0.34 пунктээр, эрэгтэйчүүдийнх 66.11 болж 0.23 пунктээр өссөн байна. Дундаж наслалтын хувьд хүйсийн ялгаа аль ч улс оронд байдаг ба эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс дунджаар 4 насаар илүү амьдардаг байна. Манай улсын хувьд эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс 9.67 жилээр илүү байна.

1.2. Эрүүл мэндийн үзүүлэлт


1.2.1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан

2018 оны байдлаар хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгааныг 10 000 хүн амд авч үзвэл:

- Амьсгалын тогтолцооны өвчин, 1712.4
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин, 1548.4
- Зүрх-судасны тогтолцооны өвчин, 1149.5
- Шээс бэлгийн тогтолцооны өвчин, 932.4
- Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг, 585.2

2018 онд хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгааныг байршлаар авч үзвэл хот, хөдөөд амьсгалын тогтолцооны өвчин, хоол боловсруулах тогтолцооны өвчин, зүрх-судасны тогтолцооны өвчин тэргүүлэх 3 шалтгаанд орж байна. Тухайлбал 10 000 хүн амд ногдох амьсгалын тогтолцооны өвчин хотод 1571.0, хөдөөд 1829.4, хоол боловсруулах тогтолцооны өвчин хотод 1576.5, хөдөөд 1525.2, зүрх-судасны тогтолцооны өвчин хотод 1095.1, хөдөөд 1194.5, шээс бэлгийн тогтолцооны өвчин хотод 947.9, хөдөөд 919.5, гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг хотод 1026.5, хөдөөд 219.7 ногдож байна.


2017 онтой харьцуулахад хоол боловсруулах тогтолцооны өвчин, шээс бэлгийн тогтолцооны эмгэгээс бусад өвчлөлийн тэргүүлэх шалтгаанууд өссөн үзүүлэлттэй байна /Зураг 1/.



Зураг 1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан 10 000 хүн амд /2013-2018 он/

1.2.2. Хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан

Монгол улсын хүн амын нас баралтын шалтгаанд амьсгалын тогтолцооны өвчин, хавдар, зүрх-судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт 1990 онд тэргүүлж байсан бол 1995 оноос одоог хүртэл зүрх-судасны тогтолцооны өвчин, хавдар, гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралт тэргүүлсээр байна.



Зураг 2. Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүн амд /2013-2018 он/

2018 онд хүн амын нас баралтын шалтгааны 34.4 хувийг зүрх-судасны тогтолцооны өвчин, 24.6 хувийг хавдар, 16.8 хувийг гэмтэл хордлого, нас баралтын гадны шалтгаант, 6.8 хувийг хоол боловсруулах тогтолцооны өвчин, 4.3 хувийг амьсгалын тогтолцооны өвчин эзэлж байгаа нь нас баралтын шалтгааны 87.1 хувийг эзэлж байна.

2018 оны нас баралтын тэргүүлэх 5 шалтгаанаас авч үзвэл жилд дунджаар 5000-5500 гаруй хүн буюу нас барсан 3 хүний нэг нь зүрх-судасны тогтолцооны өвчин, 4000 гаруй хүн хавдраар, 2500 гаруй хүн буюу нас барсан 6 хүний нэг нь гэмтэл хордлого, нас баралтын гадны шалтгаант өвчний улмаас нас барж байна.

2018 оны байдлаар хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан 10 000 хүн амд:

- Зүрх-судасны тогтолцооны өвчин 18.88
- Хавдар 13.64
- Гэмтэл хордлого, нас баралтын гадны шалтгаант 9.25
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин 3.76
- Амьсгалын тогтолцооны өвчин 2.38 орж байна.

ЭМ ЗҮЙН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

2.1. Эрх зүй, бодлого

Эм зүйн салбарт мөрдөх бодлогын дараах баримт бичиг 2018 онд шинээр батлагдсан байна.

1. “Цахимаар эмийн жор бичих, олгох заавар” батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/262 дугаар тушаал)

2018 оны байдлаар Монгол улсын эм зүйн салбарт дараах эрх зүйн баримт бичгийг мөрдөн ажиллав. Үүнд:

1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого (Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоол)
2. “Эрүүл мэндийн тухай” Монгол Улсын хууль (2011 оны 05 дугаар сарын 05-ны өдөр)
3. “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” Монгол Улсын хууль (2010 оны 05 дугаар сарын 27-ны өдөр)
4. “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” Монгол Улсын хууль (2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр)
5. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” Монгол улсын хууль (2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр),
6. Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг тогтоох тухай (Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 73 дугаар тогтоол)
7. Хлорт фторт нүүрстөрөгч агуулсан ингальяци хэлбэрийн эмийн бүртгэлийг зогсоох тухай (Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2009 оны 217/259 дүгээр тушаал)
8. Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг зохицуулах журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2009 оны 388 дугаар тушаал)
9. Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаал)
10. Төлбөрийг нь төр хариуцах эмийг олгох журам батлах тухай (Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2012 оны 129/100 дугаар тушаал)
11. Эмийн гаж нөлөө болон аюулгүй байдлын мэдээллийг бүртгэн, мэдээлэх журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2013 оны 415 дугаар тушаал)
12. Эмийн зах зээлийн дараах тандалт судалгаа хийх журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2014 оны 33 дугаар тушаал)
13. Фармакопей боловсруулах, батлах, дугаар өгөх, фармакопейн хорооны бүрэлдэхүүн, ажиллах журам шинэчлэн батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2014 оны 132 дугаар тушаал)
14. “Эмийн эмчилгээг зохицуулах хорооны ажиллах журам” батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2014 оны 336 дугаар тушаал)
15. Эм, эмийн түүхий эдийг бүртгэх журам батлах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 13 дугаар тушаал)

16. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам батлах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 68 дугаар тушаал)
17. Эмийн зах зээлийн дараах тандалт судалгаа хийх журамд өөрчлөлт оруулах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 88 дугаар тушаал)
18. “Эмийн гаж нөлөө болон эмийн аюулгүй байдлын мэдээллийг бүртгэн мэдээлэх журам”-д өөрчлөлт оруулах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 89 дүгээр тушаал)
19. Бүртгэлийн болон GMP-ын шинжээч ажиллуулах журам батлах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 225 дугаар тушаал)
20. Өнчин эмийн жагсаалт батлах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 271 дүгээр тушаал)
21. Өнчин эмийн жагсаалтад нэмэлт оруулах тухай (Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/30 дугаар тушаал)
22. Өнчин эмийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай (Эрүүл мэндийн сайдын 2017 оны 211 дүгээр тушаал)
23. Өнчин эмийн жагсаалтад нэмэлт оруулах тухай (Эрүүл мэндийн сайдын 2017 оны 301 дүгээр тушаал)
24. Гадаад, дотоодын эм үйлдвэрлэгчийн төлөөлөгчийн газрын ажиллах журам (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 284 дугаар тушаал)
25. Эмийн чанарыг хангах чиглэлээр оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө батлах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны А/286 дугаар тушаал)
26. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай (Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/28 дугаар тушаал)
27. Эм зүйч, эм найруулагчийн ёс зүйн хэм, хэмжээ эрх үүрэг батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2016 оны 32 дугаар тушаал)
28. Эмийн эмнэлзүйн туршилт явуулах журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/56 дугаар тушаал)
29. Хүний эмийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/127 дугаар тушаал)
30. Журамд өөрчлөлт оруулах тухай (Монгол улсын хүн амын эмчилгээнд хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт) (Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/184 дүгээр тушаал)
31. Эм зүйн салбарын сайн засаглалын удирдамж батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/190 дүгээр тушаал)
32. Тусламж, хандиваар эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх, хүлээн авах, хэрэглэх журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/232 дугаар тушаал)
33. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийг бүртгэн мэдээлэх, тандах журамд өөрчлөлт оруулах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/278 дугаар тушаал)
34. Эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдлын програмыг нэвтрүүлэх журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/19 дугаар тушаал)
35. Төлөвлөгөө батлах тухай (Нянгийн тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын үйл

- ажиллагааны төлөвлөгөө 2017-2020 он) (Эрүүл мэндийн сайд, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан 2017 оны А/191, А/64 дүгээр тушаал)
36. Монгол улсын үндэсний фармакопейд өөрчлөлт оруулах тухай (Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/219 дугаар тушаал)
 37. Үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай (Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн эрүүл мэндийн салбарт хэрэгжих үйл ажиллагааны төлөвлөгөө) (Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/289 дугаар тушаал)
 38. Төлөвлөгөө батлах тухай (Эм зүйн салбарын ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө 2017-2020 он) (Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/345 дугаар тушаал)
 39. Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP/-ын батламж олгох журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/348 дугаар тушаал)
 40. Жагсаалт шинэчлэн батлах тухай (Зайлшгүй шаардлагатай эмийн 8 дахь жагсаалт) (Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/350 дугаар тушаал)
 41. Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын лиценз олгох журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/407 дугаар тушаал)
 42. Монгол улсын стандарт. Эм үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага. MNS 5524-1:2014
 43. Монгол улсын стандарт. Биобэлдмэлийн үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага. MNS 5524-2:2014
 44. Монгол улсын стандарт. Уламжлалт эмийн үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага. MNS 5524-3:2015
 45. Монгол улсын стандарт. Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага. MNS 5530:2014
 46. Монгол улсын стандарт. Эмийн идэвхт бодис ба эмийн тогтвортой чанарын судалгаанд тавих ерөнхий шаардлага. MNS 6439:2014
 47. Монгол улсын стандарт. Эмийн жорын маягт, жор бичилтийн стандарт MNS 5376:2016
 48. Монгол улсын стандарт. Биологийн идэвхт бүтээгдэхүүн ханган нийлүүлэх байгууллагад тавих шаардлага MNS 6396:2013
 49. Монгол улсын стандарт. Фармакопейн өгүүлэл боловсруулах арга зүй. MNS 5763:2015
 50. Монгол улсын стандарт. Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага. MNS 5260:2015
 51. Монгол улсын стандарт. Эмийн чанарын хяналтын лабораторид тавих шаардлага. MNS 6621-2016
 52. Монгол улсын стандарт. Эмийн анхдагч савлалтын материалд тавих ерөнхий шаардлага. MNS 6622-2016
 53. “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай (Шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалт) (Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоол)
 54. Эмнэлгийн эм зүйн албаны үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрэм батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/180 дугаар тушаал)


2.2. Эм хангамжийн байгууллагын үзүүлэлт

Эм хангамжийн байгууллагын үзүүлэлтийг дараах чиглэлээр гаргав.

- Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр
- Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага
- Эмийн сан


2.2.1. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр

2018 оны байдлаар Монгол улсын хэмжээнд эм, эмнэлгийн хэрэгслийн нийт 41 үйлдвэр дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулсан байна. Үүнд:



Зураг 3. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрийн үйл ажиллагааны чиглэл, 2018 он


2018 онд эм, эмнэлгийн хэрэгслийн 41 үйлдвэр, ханган нийлүүлэх 360 байгууллага үйл ажиллагаа явуулсан байна.



Зураг 4. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр,
Эм ханган нийлүүлэх байгууллагын тоо, /2013-2018 он/


2.2.2. Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага

2018 оны байдлаар нийт тусгай зөвшөөрөлтэй 360 ханган нийлүүлэх байгууллага дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулсан байна. Үүнд:



Зураг 5. Ханган нийлүүлэх байгууллагын үйл ажиллагааны чиглэл /давхардсан тоогоор/, 2013-2018 он

2018 онд шинээр 35 байгууллага ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийг авсан байна. Үүнд:



Зураг 6. Тусгай зөвшөөрөл авсан ханган нийлүүлэх байгууллагын үйл ажиллагааны чиглэл /давхардсан тоогоор/, 2018 он

2.2.3. Эмийн сан

2018 онд улсын хэмжээнд 2128 эмийн сан үйл ажиллагаа явуулснаас орон нутагт 924, нийслэлд 1204 эмийн сан ажиллаж, нийслэлд 325, орон нутагт 510 эмийн сан Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох эмээр иргэдэд үйлчилсэн байна.

Хүснэгт 2. Эмийн сан, бүсээр, 2018 он

№	Аймаг, хотын нэр	1-р зэрэглэлийн хувийн эмийн сангийн тоо	2-р зэрэглэлийн эмийн сангийн тоо		Нийт
			Эмийн эргэлтийн сан	Хувийн эмийн сан	
Баруун бүс					
1	Баян-Өлгий	2	13	27	42
2	Говь-Алтай	1	19	14	34
3	Завхан	4	21	21	46
4	Увс	9	18	13	40
5	Ховд	12	16	12	40
Хангайн бүс					
1	Архангай	4	0	39	43
2	Баянхонгор	6	20	15	41
3	Булган	2	15	19	36
4	Орхон	36	-	21	57
5	Өвөрхангай	5	18	30	53
6	Хөвсгөл	2	23	46	71
Төвийн бүс					
1	Говьсүмбэр	-	-	10	10
2	Дархан-Уул	8	-	52	60
3	Дорноговь	11	16	16	43
4	Дундговь	3	15	6	24
5	Өмнөговь	3	14	24	41
6	Сэлэнгэ	9	20	35	64
7	Төв	1	26	29	56
Зүүн бүс					
1	Дорнод	9	13	24	46
2	Сүхбаатар	3	12	13	28
3	Хэнтий	4	21	24	49
Орон нутгийн хэмжээнд		134	300	490	924
Улаанбаатар		129	-	1075	1204
Улсын хэмжээнд		263	300	1565	2128

Монгол улсын хэмжээнд 2018 оны байдлаар нийт 2128 эмийн сан үйл ажиллагаа явуулж байна. Үүнд 300 эмийн эргэлтийн сан, 1828 хувийн эмийн сан ажиллаж байгаагаас 263 нь 1-р зэрэглэл, 1565 нь 2-р зэрэглэлийн эмийн сан байна.

2018 онд улсын хэмжээнд эмийн сангийн 135 эмийн санд тусгай зөвшөөрөл шинээр олгосон байна.

Хүснэгт 3. Эмийн сангийн тусгай зөвшөөрөл, бүсээр, 2018 он

№	Аймаг, хотын нэр	Тусгай зөвшөөрөл хүссэн	Тусгай зөвшөөрөл олгосон	Тусгай зөвшөөрөл сунгасан
Баруун бүс				
1	Баян-Өлгий	6	6	21
2	Говь-Алтай	1	1	4
3	Завхан	3	3	14
4	Увс	-	-	-
5	Ховд	5	4	9
Хангайн бүс				
1	Архангай	5	5	15
2	Баянхонгор	4	4	8
3	Булган	2	2	1
4	Орхон	2	2	8
5	Өвөрхангай	6	3	29
6	Хөвсгөл	10	4	-
Төвийн бүс				
1	Говьсүмбэр	2	2	5
2	Дархан-Уул	2	2	40
3	Дорноговь	5	5	2
4	Дундговь	1	1	22
5	Өмнөговь	5	3	14
6	Сэлэнгэ	-	-	21
7	Төв	2	-	1
Зүүн бүс				
1	Дорнод	2	2	0
2	Сүхбаатар	3	2	8
3	Хэнтий	2	2	4
	Орон нутгийн хэмжээнд	68	53	222
Улаанбаатар		186	82	350
	Улсын хэмжээнд	254	135	576

2.3 Хүний нөөцийн үзүүлэлт

2018 оны байдлаар Монгол улсын хэмжээнд нийт 2169 эм зүйч, 2010 эм найруулагч ажилласнаас эрүүл мэндийн салбарт 2074 эм зүйч, 1198 эм найруулагч ажилласан байна.

Хүснэгт 4. Эм зүйч, эм найруулагчийн тоо, тусламж үйлчилгээний шатлалаар,
2014-2018 он


Эрүүл мэндийн байгууллагууд	Эм зүйч					Эм найруулагч				
Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага	2014	2015	2016	2017	2018	2014	2015	2016	2017	2018
Тосгоны эмнэлэг	2	2	1	1	1	9	9	11	12	11
Сумын эрүүл мэндийн төв	10	13	14	19	26	180	184	166	134	141
Сум дундын эмнэлэг	1	3	2	4	4	29	28	24	20	18
Бүгд	13	18	17	24	31	218	221	201	166	170
Дүүргийн нэгдсэн эмнэлэг	26	24	25	29	33	15	18	18	21	20
Аймгийн нэгдсэн эмнэлэг	24	25	25	33	37	41	40	38	40	48
Бүгд	50	49	50	62	70	56	58	56	61	68
Бүсийн оношилгоо эмчилгээний төв	14	13	16	17	20	15	16	14	12	13
Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төв	71	77	84	84	89	35	30	30	26	24
Бүгд	85	90	100	101	109	50	46	44	38	37
Амаржих газар	11	10	9	9	9	2	2	2	3	3
Ортой хувийн эмнэлэг	37	44	54	58	10	33	30	34	33	12
Үүдэн хувийн эмнэлэг (клиник)	5	16	18	14	10	2	5	4	6	10
Эрүүл мэндийн яам, агентлаг	9	12	14	13	14	0	0	0	0	0
Эрдэм шинжилгээний байгууллага	1	0	0	0	5	0	0	0	0	0
Эрүүл мэндийн газар	16	14	18	16	2	2	4	4	3	0
Яаралтай тусламжийн төв, дүүргүүд дэх салбар	1	1	1	1	1	5	7	9	9	10
Сувилал	2	2	2	3	2	1	1	1	1	1
Эм ханган нийлүүлэх байгууллага	123	148	81	107	107	136	134	92	109	115
Эмийн үйлдвэр	24	17	93	108	100	14	7	25	21	46
Хувийн эмийн сан	1160	1027	1124	1473	1699	1292	1275	1224	1521	1538
Бүгд (Эрүүл мэндийн салбарт)	1389	1291	1414	1802	1959	1487	1465	1395	1706	1735
Улсын АУ-ны сургууль, коллеж	29	36	27	29	40	5	2	1	1	1
Хувийн АУ-ны сургууль, коллеж	18	-	34	38	35	38	-	-	1	0
Бусад эмнэлэг (Хилийн цэрэг, хорихын эмнэлэг, Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг, Төмөр замын төв эмнэлэг)	19	19	19	18	20	11	11	12	13	11
Бүгд (Бусад салбарт)	66	55	80	85	95	54	13	13	15	12
Нийт	1537	1448	1581	1989	2169	1811	1790	1696	1971	2010

2018 онд орон нутагт эрүүл мэндийн салбарт ажилласан эм зүйч, эм найруулагчийн тоог байршлаар дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 5. Эм зүйч, эм найруулагчийн тоо, аймгаар, 2018 он


№	Аймаг	Эм зүйч	Эм найруулагч
Баруун бүс			
1	Баян-Өлгий	35	58
2	Говь-Алтай	21	53
3	Завхан	27	49
4	Увс	37	40
5	Ховд	44	51
Хангайн бүс			
1	Архангай	31	66
2	Баянхонгор	34	52
3	Булган	15	42
4	Орхон	79	91
5	Өвөрхангай	30	49
6	Хөвсгөл	38	75
Төвийн бүс			
1	Говьсүмбэр	8	20
2	Дархан-Уул	61	99
3	Дорноговь	31	78
4	Дундговь	14	27
5	Өмнөговь	41	52
6	Сэлэнгэ	32	90
7	Төв	13	35
Зүүн бүс			
1	Дорнод	26	48
2	Сүхбаатар	16	34
3	Хэнтий	24	53
Улаанбаатар		1503	929
Нийт		2160	1005

2018 онд эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эм зүйч, эм найруулагчийн тоо 2017 онтой харьцуулахад өссөн байна.




Зураг 7. Эм зүйч, эм найруулагчийн тоо, 2013-2018 он

Улсын болон хувийн хэвшлийн их, дээд сургуульд эм зүйч, эм найруулагчийг бэлтгэж байна. 2018 онд нийт 395 төгсөгч эм зүйч, 64 төгсөгч эм найруулагч мэргэжлээр төгссөн байна.




Зураг 8. Эм зүйч мэргэжлээр төгсөгчдийн тоо, 2013-2018 он

2018 онд АШУУИС (хуучин нэрээр ЭМШУИС)-ийн Эм зүйн сургуулийг 94, ЭЗШУИС (хуучин нэрээр Монос дээд сургууль)-ийг 125, Этүгэн их сургуулийг 60, ШАУИС-ийг 116 төгсөгч эм зүйч мэргэжлээр төгссөн байна.



Зураг 9. Эм найруулагч мэргэжлээр төгсөгчдийн тоо, 2013-2018 он

2018 онд АШУУИС-ийн Эм зүйн сургуулийг 14, Дарханы АУК-ийг 22, Дорноговийн АУК-ийг 7, Говь-Алтайн АУК-ийг 21 төгсөгч эм найруулагч мэргэжлээр төгссөн байна.



Зураг 10. Эм зүйч, эм найруулагч мэргэжлээр төгсөгчдийн тоо, 2013-2018 он


2013-2018 онд төгссөн эм зүйч болон эм найруулагчдын тоог харьцуулахад эм зүйч мэргэжлээр төгсөгчдийн тоо нэмэгдсэн, эм найруулагч мэргэжлээр төгсөгчдийн тоо буурсан байна.

2.4. Эдийн засгийн үзүүлэлт

2.4.1. Эмийн санхүүжилт

Эрүүл мэндийн салбарын төсөв 2018 онд 766.3 тэрбум төгрөг болсон нь өмнөх онтой харьцуулахад 91.9 тэрбум төгрөгөөр, эмийн төсөв 109.1 болсон нь 12.5 тэрбум төгрөгөөр өссөн байна /Зураг 11/.

Эрүүл мэндийн салбарын төсөвд эмийн зардалын эзлэх хувь 2013 онд 12.5 хувь байсан бол 2017 онд 14.3 хувь болж өссөн, харин 2018 онд өнгөрсөн жилтэй харьцуулахад 0.1 хувиар буурсан байна /Хүснэгт 6/.



Зураг 11. Эрүүл мэндийн салбарын төсөв, тэрбум төгрөгөөр, 2013-2018 он


Хүснэгт 6. Эм зүйн салбарын эдийн засгийн зарим үзүүлэлт, 2013-2018 он

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018
Эрүүл мэндийн салбарын зардал (тэрбум төг)	520.5	566.1	581.9	657.5	674.4	766.3
Эмийн зардал (тэрбум төг)	60.4	68.5	70.4	86.6	96.6	109.1
Эрүүл мэндийн салбарын зардалд эмийн зардалын эзлэх хувь	12.5	11.5	12.1	13.2	14.3	14.2
Эрүүл мэндийн даатгалаас олгосон эмийн үнийн хөнгөлөлт	11.2	11.3	16.05	26.63	38.1	37.8


2.4.2. Эмийн үйлдвэрлэл, худалдаа

2.4.2.1 Эмийн импорт

2018 онд эмийн 362.5 тэрбум төгрөгийн импорт, 299 тэрбум төгрөгийн борлуулалт (бөөний үнээр) хийсэн нь 2017 онтой харьцуулахад эмийн импорт 128.4 тэрбум төгрөг, эмийн борлуулалт 77.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.




Зураг 12. Эмийн импорт, борлуулалт, тэрбум төгрөгөөр 2013-2018 он




Зураг 13. Эмийн түүхий эдийн импорт, борлуулалт, тэрбум төгрөгөөр, 2013-2018 он

2018 онд 3.5 тэрбум төгрөгийн эмийн түүхий эдийн импорт, 2.5 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх онтой харьцуулахад эмийн түүхий эдийн импорт 1.16 тэрбум төгрөг, борлуулалт 0.29 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.




Зураг 14. Эмнэлгийн хэрэгслийн импорт, борлуулалт /тэрбум төгрөг/ 2013-2018 он

2018 онд 83 тэрбум төгрөгийн эмнэлгийн хэрэгсэлийн импорт, 70.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь 2017 онтой харьцуулахад эмнэлгийн хэрэгслийн импорт 95.2 тэрбум төгрөгөөр, борлуулалт 29 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.




Зураг 15. Урвалж, оношлуурын импорт, борлуулалт, тэрбум төгрөгөөр, 2013-2018 он


2018 онд нийт 27 тэрбум төгрөгийн урвалж, оношлуурын импорт, 24.5 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх онтой харьцуулахад импорт 4.9 тэрбум төгрөг, борлуулалт 3.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.



Зураг 16. Урвалжийн импорт, борлуулалт /тэрбум төгрөг/, 2013-2018 он



Зураг 17. Оношлуурын импорт, борлуулалт /тэрбум төгрөг/, 2013-2018 он




Зураг 18. Импортолсон бүтээгдэхүүн, нэр төрлөөр, 2014-2018 он /давхардсан тоогоор/

Импорт, экспортын лицензийг Засгийн газрын 2002 оны 219 дүгээр тогтоолын дагуу “Төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд”, ЭМС-ын 2017 оны Импорт, экспортын лиценз олгох 407 дугаар, ЭМСС-ын “Тусламж, хандиваар эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх, хүлээн авах, хэрэглэх” А/232 дугаар журмыг тус тус үндэслэн ажлын 1-5 хоногт багтаан олгодог.

2.4.2.2. Эмийн үйлдвэрлэл


Үндэсний үйлдвэрийн эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, уламжлалт эм, ариутгал халдваргүйтгэлийн бодисын үйлдвэрлэл сүүлийн 3 жилд өссөн байна.



Зураг 19. Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тэрбум төгрөгөөр, 2013-2018 он

2018 онд Монгол улсын хэмжээнд 41 эмийн үйлдвэр ажиллаж нийт 44.4 тэрбум төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, уламжлалт эм, ариутгал халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэж, 43.2 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна. Үүнээс 39.4 тэрбум төгрөгийн европ эм үйлдвэрлэж 38.4 тэрбум төгрөгийн борлуулалт, 141 сая төгрөгийн уламжлалт эм үйлдвэрлэж 198 сая төгрөгийн борлуулалт, 1.3 тэрбум төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэж 549 сая төгрөгийн борлуулалт, 933 сая тэрбум төгрөгийн ариутгал халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэж 1.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрлийг авч үзвэл:



Зураг 20. Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл, 2014-2018 он


2018 онд эмийн үйлдвэрүүд нийт 503 нэр төрлийн эм үйлдвэрлэснээс 276 (54.9%) нэрийн эм, 17 (3.38%) нэрийн эмнэлгийн хэрэгсэл, 61 нэр төрлийн биологийн идэвхт бүтээгдэхүүн (12.1%), 116 нэрийн уламжлалт эм (23.0%), 33 нэрийн ариутгал халдваргүйтгэлийн бодис (6.6%) үйлдвэрлэсэн байна.

Борлуулалтаар авч үзвэл 2018 онд эх орны эмийн үйлдвэрийн эм дотоодын эмийн зах зээлийн 14 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 0.78 хувиар буурсан байна. Үндэсний эмийн үйлдвэрүүд 0.549 төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл борлуулсан нь дотоодын зах зээлийн 0.77 хувийг эзэлж байна.

2.4.3. Эм худалдан авах ажиллагаа, түгээлт


Эрүүл мэндийн байгууллагад эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль”-ийн дагуу

хийж гүйцэтгэж байна. Нэр төрлийн хувьд дунджаар нэг байгууллага 400 гаруй нэрийн эм, 300 орчим нэрийн эмнэлгийн хэрэгсэл, 500 орчим нэрийн урвалж, оношлуурыг хэрэглэж байна.




Зураг 21. Эм, эмнэлгийн хэрэгслийн төсөвт өртөг ба худалдан авах ажиллагааны гэрээний дүн, /тэрбум төгрөг/, 2013-2018 он

Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан тендерийн гэрээний дүнг нийслэл, орон нутгаар авч үзвэл:



Зураг 22. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан гүйцэтгэлийн дүн, тэрбум төгрөгөөр, 2013-2018 он



Зураг 23. Төлбөрийг нь төр хариуцах эм тэрбум төгрөгөөр 2013-2018 он

2018 онд зарласан эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагаагаар Нийслэлийн эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв нь эм 21.7 тэрбум, эмнэлгийн хэрэгсэл 7.4 тэрбум, урвалж оношлуур 11 тэрбум, вакцин биобэлдмэл 3.1 тэрбум, төлбөрийг нь төр хариуцах эм 16.7 тэрбум төгрөгөөр тус тус авсан байна.

2.5. Эмийн зохицуулалт

2.5.1. Эмийн бүртгэл

Хүн ам, эрүүл мэндийн байгууллагыг чанартай, аюулгүй эмчилгээний идэвхтэй эмээр хангах зорилгоор эмийн бүртгэлийн үйл ажиллагааг Монгол улсад 1994 оноос хэрэгжүүлж эхэлсэн.


Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 22 дугаар зүйлд үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2015 оны 13 дугаар “Эм, эмийн түүхий эдийг бүртгэх журам шинэчлэн батлах тухай” тушаалын дагуу эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна.



Зураг 24. Монгол улсын эмийн бүртгэлд шинээр бүртгэгдсэн эм, эмийн түүхий эд 1994-2018 он


2018 онд улсын бүртгэлд 500 нэрийн эм шинээр нэмж бүртгэснээс импортын 419, уламжлалт 38, эх орны 31 эм, 12 эмийн түүхий эдийг бүртгэсэн байна. 2018 онд 682 эм, 19 эмийн түүхий эдийн бүртгэлийн хугацааг сунгаж, 473 эмийн бүртгэлд өөрчлөлт оруулж, 24 нэрийн эм бүртгэлээс хассан.

2018 онд Монгол улсын эмийн бүртгэлд нийт 5916 /савлалт давхардаагүй тоогоор 4878/ эм, 259 нэрийн түүхий эд бүртгэлтэй байна.




Зураг 25. Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм, эмийн түүхий эдийн тоо 2013-2018 он

Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн нийт эмийг 2018 оны сүүлийн байдлаар АТС ангиллаар авч үзвэл:




Зураг 26. Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм, АТС ангилал, 2013-2018 он

2018 оны байдлаар Монгол улсад нийт бүртгэлтэй 5916 эмийн 31.4% жоргүй олгох, 68% жороор олгох, 0.6% эмнэлгийн нөхцөлд хэрэглэх эм байна.




Зураг 27. Бүртгэлтэй эмийн олгох нөхцөл /хувиар/, 2018 он

Манай улсын эмийн бүртгэлд үйлдвэрлэсэн эм нь хамгийн их бүртгэгдсэн эхний 10 улсыг авч үзвэл:




Зураг 28. Монгол улсын эмийн бүртгэлд эм бүртгүүлсэн эхний 10 улс, хувиар, 2018 он

Үндэсний эмийн үйлдвэрийн эм нийт бүртгэлтэй эмийн 29.8%-ийг эзэлж байна.




Зураг 29. Эмийн бүртгэлд үндэсний үйлдвэрийн эмийн эзлэх хувь, 2013-2018 он

Монгол улсын эмийн бүртгэлд 2018 онд бүртгэгдсэн нийт эмийг АТС кодын ангиллаар авч үзвэл:




Зураг 30. Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм, АТС ангиллаар, 2018 он

2014-2018 онд эмийн бүртгэлд шинээр бүртгэгдсэн эмийг авч үзвэл:




Зураг 31. Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм /төрлөөр/, 2014-2018 он

Үндэсний үйлдвэрийн эмийн бүртгэлийг бүртгэгдсэн оноор харьцуулбал:



Зураг 32. Үндэсний үйлдвэрийн эмийн бүртгэл, 2014-2018 он




Зураг 33. Уламжлалт эмийн бүртгэл, 2014-2018 он

2.5.2. Хяналт шалгалт

Эм хангамжийн байгууллагын хяналт шалгалтыг МХЕГ-аас “Төрийн хяналт шалгалтын хууль”-ийн дагуу явуулж байна.


2018 онд хяналт шалгалтад хамрагдсан эм хангамжийн байгууллагын тоог авч үзвэл:



Зураг 34. Хяналт шалгалтад хамрагдсан эм хангамжийн байгууллагын тоо, 2014-2018 он

2018 онд 573 эм хангамжийн байгууллага хяналт шалгалтад хамрагдсан нь 2017 онтой харьцуулахад хяналт шалгалтад хамрагдсан эм хангамжийн байгууллагын тоо 51-р нэмэгдсэн байна.


Нийт тусгай зөвшөөрөлтэй эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллагад хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын эзлэх хувийг авч үзвэл:



Зураг 35. Хяналт шалгалтад хамрагдсан эм хангамжийн байгууллагын хувь, 2014-2018 он

2.5.3. Зах зээлийн ба чанарын хяналт


МХЕГ-ын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Эм, биобэлдмэлийн хяналтын лаборатори 2017 онд нийт 1517 дээжийг шинжилсэн байна. Тус лаборатори бүртгэлийн болон хяналт шалгалтын дээж, албан байгууллагын хүсэлтээр эмийн шинжилгээ хийж байна.




Зураг 36. Шинжилгээнд хамрагдсан дээж, 2013-2018 он

Шинжилсэн нийт дээжийн ихэнх хувийг албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хүсэлтээр шинжилсэн дээж эзэлж байгаа ба уг үзүүлэлт 2013 онд 54.48%, 2014 онд 40.97%, 2015 онд 48.79%, 2016 онд 60.39%, 2017 онд 52.27%, 2018 онд 52.4% байв.

2017 онд нийт 1517 дээж шинжилсний 194 дээж нь чанарын шаардлага хангаагүй нь шинжилгээнд хамрагдсан дээжийн 12.7% хувийг эзэлж байна.



Зураг 37. Нийт шинжилсэн ба чанарын шаардлага хангаагүй дээжийн тоо, 2013-2018 он



Зураг 38. Чанарын шаардлага хангаагүй дээжийн эзлэх хувь, 2013-2018 он

2018 онд нийт шинжилсэн дээжинд чанарын шаардлага хангаагүй дээжийн эзлэх хувь 12.78% байна. 2017 оны үзүүлэлтэй харьцуулвал 2018 онд чанарын шаардлага хангаагүй дээж 0.33% буурсан байна.

2.5.4. Эмийн аюулгүй байдал

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 415 дугаар тушаалаар баталсан “Эмийн гаж нөлөө болон аюулгүй байдлын мэдээллийг бүртгэн мэдээлэх журам”-ын дагуу эмийн гаж нөлөөг мэдээлэх, бүртгэх үйл ажиллагааг явуулж байна.

2018 онд эмийн гаж нөлөөний 102 тохиолдлыг мэдээлсэн байна. 2012-2018 онд Эрүүл мэндийн 115 байгууллагаас эмийн гаж нөлөөний 879 тохиолдол бүртгэгдэж ирснийг Эм судлалын салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна.

Хүснэгт 7. Эмийн гаж нөлөөний бүртгэл /2013-2018 он/

Үзүүлэлт		2012	2013	2014	2015	2016	2017	2018
Улаанбаатар хотын эмнэлэг, эмийн сан	Мэдээлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо	8	14	11	5	16	9	15
	Гаж нөлөөний тоо	57	111	98	44	117	59	95
Хөдөө орон нутгийн эмнэлэг, эмийн сан	Мэдээлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо	2	7	7	8	6	7	2
	Гаж нөлөөний тоо	8	66	60	24	106	27	7
Нийт	Мэдээлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо	10	21	18	13	22	15	16
	Гаж нөлөөний тоо	65	177	158	68	223	86	102

2.5.5 Эмийн сонголт, эмийн зохистой хэрэглээ


Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь заалтыг үндэслэн эмийн хангамж, хүртээмжийг сайжруулах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Жагсаалт шинэчлэн батлах тухай” 350 дугаар тушаалаар Зайлшгүй шаардлагатай эмийн 8 дахь жагсаалтыг баталсан /Хүснэгт 8/.

Хүснэгт 8. Монгол улсын Зайлшгүй шаардлагатай эмийн үндэсний жагсаалт, түгээх салбар, эмнэлэг, мэргэжлийн төв, эмийн сангаар


№	ЗШЭҮЖ	Багийн бага эмчийн салбар	Өрхийн эмнэлэг	Сумын эмнэлэг	Сум дундын эмнэлэг	Аймаг, дүүргийн эмнэлэг	БОЭТ	Клиникийн эмнэлэг, нарийн мэргэжлийн төв	Нийтийн үйлчил- гээтэй эмийн сан
Эмийн тоо /давхардсан тоогоор/									
1	3 дахь жагсаалт (1997)	42	-	179	-	264	-	301	-
2	4 дэх жагсаалт (2001)	56	-	194	226	295	-	319	-
3	5 дахь жагсаалт (2005)	83	116	207	236	303	-	338	-
4	6 дахь жагсаалт (2009)	105	-	260	336	398	-	419	-
5	7 дахь жагсаалт (2014)	87		271	353	540	589	664	499
6	8 дахь жагсаалт (2017)	77	-	260	-	535	-	709	-

Хүний эмийн зөвлөлийн дэргэдэх Эм судлалын салбар зөвлөлөөр жоргүй олгох эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааг тус тус хэлэлцэж олон нийтийн мэдээллийн хэрэгсэл /телевиз/-ээр сурталчлах зөвшөөрлийг олгодог.

2015-2018 онд зар сурталчилгааны зөвшөөрөл хүссэн 174 нэрийн эм, 38 нэрийн биологийн идэвхт бүтээгдэхүүнд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл /телевиз/-ээр сурталчлах зөвшөөрөл олгосон байна.



Зураг 39. Зөвшөөрөл олгосон зар сурталчилгааны тоо, 2015-2018 он



Зураг 40. Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнд олгосон зар сурталчилгааны тоо, 2015-2018 он

Ашигласан материал

1. Эрүүл мэндийн үзүүлэлт 2012, Эрүүл мэндийн хөгжлийн төв, 2013, Улаанбаатар
2. Эрүүл мэндийн үзүүлэлт 2013, Эрүүл мэндийн хөгжлийн төв, 2014, Улаанбаатар
3. Эрүүл мэндийн үзүүлэлт 2014, Эрүүл мэндийн хөгжлийн төв, 2015, Улаанбаатар
4. Эрүүл мэндийн үзүүлэлт 2015, Эрүүл мэндийн хөгжлийн төв, 2016, Улаанбаатар
5. Эрүүл мэндийн үзүүлэлт 2016, Эрүүл мэндийн хөгжлийн төв, 2017, Улаанбаатар
6. Эрүүл мэндийн үзүүлэлт 2017, Эрүүл мэндийн хөгжлийн төв, 2018, Улаанбаатар
7. ЭМЯ, ЭЭХҮХ-ийн тайлан, 2018
8. ЭМХТ, ЭЭТТА-ны тайлан, 2018
9. МХЕГ-ын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Эм, биобэлдмэлийн хяналтын лаборатори тайлан, 2018